



**Олон улсын бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн жилийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийн БЭЛЧЭЭР ба ЖЕНДЕР хэсгийн гишүүдийн үзэж байгаагаар нүүдлийн мал аж ахуйн ирээдүй дараах зүйлсээс хамаарна**

**1. Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн жендерийн асуудлыг гүн гүнзгий ойлгох**

Ажлын хэсэг нь бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйн бүхий л асуудалд жендерийн оролцоог хангахыг зөвлөж байна. Бэлчээрийн мал аж ахуйн тогтолцооны олон талт байдлыг харгалзан жендерийн баримжаа, жендерийн үүрэг, халамж үйлчилгээ болон гэр бүл, үндсэн болон үндсэн бус давхар ажлыг тэгш эрхийгалдагдуулалгүйгээр тооцох хэрэгтэй. Мөн түүнчлэн малчин эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь, дуу хоолойг дэмжиж байна. Эмэгтэйчүүдийн зүгээс зохион байгуулж буй хөдөлгөөн, дуу хоолойгоо хүргэж буй арга хэмжээг олон улсын бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн жил, тогтвортой МАА-н үйлдвэрлэл, бэлчээрийн зохистой ашиглалтыг нэвтрүүлэх санал санаачлагын хүрээнд багтаан хэрэгжүүлэхийг завлаж байна.

**2. Газар, байгалийн баялаг, биологийн олон янз байдлыг ашиглах, уламжлалт мэдлэг мэдээллийг түгээх тэгш эрх болон зүй ёсны эрх**

Ажлын хэсгээс эмэгтэй малчдын газар, ус, тэжээлийн нөөц, биологийн олон янз байдал, мэдээллийг ашиглах эрх нь ижил тэгш байхыг дэмжиж байна.

Малчин эмэгтэй нь бэлчээр усаа хамгаалах, байгалийн нөөцийг ашиглахад эрэгтэй малчинтай ижил тэгж эрхтэй байх ёстой.

Түүнчлэн бэлчээрийн зохистой ашиглалт, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдал, орлого нэмэгдүүлэх чиглэлээр эмэгтэй малчдын арга ухаан, мэдлэг туршлага, оролцоог хүндэтгэн хүлээн зөвшөөрч байна.

Мөн бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйн аливаа үйл ажиллагаанд эмэгтэй малчдын дуу хоолойг тусгаж, төлөөлөл оруулдаг байх шаардлагатай.

Энэ ажлын хэсэг малчин эмэгтэйчүүд нэгдэн нийлж туршлагаа солилцох, өөрсдийн эрхийг хамгаалах, дуу хоолойгоо хүргэх, бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйн жилийг тохиолдуулан тэмдэглэх гол арга хэмжээний нэг болох Мерагийн тунхгийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлж байна.

**3. Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлтэй холбоотой судалгаа явуулах, бодлого боловсруулах болон засаглалд эмэгтэй малчдын оролцоог хангах**

Ажлын хэсэг нь нүүдэлч малчдад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг илүү сайн ойлгох, улмаар тэдгээрийг шийдвэрлэх оновчтой арга замыг боловсруулах зорилгоор уламжлалт болон шинжлэх ухааны мэдлэг туршлагаар арвин талуудын дунд жендерийн мэдрэмжтэй харилцан яриа өрнүүлэх зорилт тавьж байна. Ингэснээр нүүдлийн мал аж ахуй эрхлэх чиглэлээр бодлого боловсруулах, шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг нэмэгдүүлж байна.

Энэхүү ажлын хэсэг нь хамтын ажиллагааны бүхий л түвшинд хүрээнд эмэгтэйчүүдийг хүлээн зөвшөөрч, сурталчлахыг дэмжих, бэлчээрийн мал аж ахуй, бэлчээрийн талаарх мэдлэгийг түгээхдээ жендерийн мэдрэмжтэй үйл ажиллагаа явуулах, судалгаа, хөгжүүлэлт, инноваци, улмаар арга замыг сайжруулах зэрэг асуудлууд, төлөвлөлт, менежмент, бодлого боловсруулалт, сургалт зэрэгт чиглэн ажиллаж байна.

Энэхүү ажлын хэсэг нь **бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн хувьд арьс өнгөний** ялгаварлалгүй, хүчирхийлэлгүй, жендерийн мэдрэмжтэй ажиллах боломжийг хангахад онцгой анхаарч ажиллана.

Ажлын байр бэлгийн дарамт, дээрэлхэх болон бусад төрлийн хүчирхийллэлээс ангид байна. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн халамж, олон талт байдлыг дэмжих бодлогыг баримталж ажиллана.